



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
АЗДТГ-ын байр, Утас/Факс: (976) 7054 3469,
И-мэйл: p_gs@inspection.gov.mn,
Вэбсайт: www.gs.inspection.gov.mn

2020.07.10 № 09-03-002/АТ.

Шивээговь сумын 320 хүүхдийн
сургуулийн барилгын зурагт
хяналт хийсэн тухай

Танайхаас ирүүлсэн хүсэлтээр Шивээговь сумын 3-р сургуулийн барилгын зураг төсөлд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч Ж.Оюунчимэг МХЕГ-ын даргын 2017 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/164 тоот тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийг барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн дүгнэлт гаргах заавар"-ыг удирдлага болгон Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм БНБД 66-88, Байгалийн гэрэлтүүлэг ба зохиомол гэрэлтүүлэг БНБД 23-02-08, Усан хангамж, гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-16, Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНБД 41-01-11, БСШУ-ны сайд, ЭМС-ын сайд, Сангийн сайдын 2015 оны А/253|251|173 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Цэцэрлэг, ЕБС, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага"-д хэрхэн нийцэж байгаад 2020 оны 4 дүгээр сарын 07-оос 09-ний өдрүүдэд Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дэх хэсэгт заасныг үндэслэн эрүүл ахуйн урьдчилсан хяналтыг гүйцэтгэв.

Холбогдох бичиг баримтыг хянахад: Сумын Засаг даргын 2010 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/158 тоот захирамжаар Шивээговь сумын 1-р багийн нутагт одоо байгаа сургуулийн барилгын ар талд 24000 м² газар олгогдсон байна.

Барилгын зургийг аймгийн ЗДТГ-ын захиалгаар зураг төслийн ЭМ ЭС ЭЛ ХХК 2020 онд хийсэн, зургийн шифр: MSL -20-09.

Зургийн даалгаврыг аймгийн ГХБХБГ газар боловсруулсан байна.

Барилга нь А,В гэсэн 2 блокоос бүрдэх ба А блок дан, В блок нь 3 давхар байх ба барилга бүхэлдээ зорьгүй тэгш өнцөгт хэлбэрүүдтэй, төмөр бетон каркас хийцтэй,

090014P

хөнгөн блок болон өнгөлгөөний тоосгон дүүргэгч ханатай, шувуун нуруун дээвэртэй байхаар төлөвлөсөн байна.

Барилгын **1-р давхарт** үүдний хэсэг, өлгүүр, гал тогоо, хооллох танхим, бэлтгэлийн өрөө, аяга таваг угаалга, ажилчдын хувцас солих болон ариун цэврийн өрөө, хүнсний хүйтэн болон хуурай бүтээгдэхүүний агуулахууд усанд орох өрөө (эр, эм), 3 бага анги, эмчийн үзлэгийн болон тусгаарлах өрөө, спорт заал, агуулах, биеийн тамирын багшийн өрөө, сурагчдын ариун цэврийн өрөө, ХБХ-дэд зориулсан ариун цэврийн өрөө,

2-р давхарт: 4 анги, хөдөлмөрийн кабинет (эр, эм), багш нарын болон эрхлэгчийн өрөө, номын сан, номын сангийн фондын өрөө, багш сурагчдын ариун цэврийн өрөөнүүд, үйлчлэгчийн өрөө,

3-р давхарт: анги танхим 3, хими физикийн лаборатори, мэдээлэлзүйн кабинет, захирлын өрөө, багш сурагчдын ариун цэврийн өрөөнүүд, тайз бүхий урлаг заал байхаар төлөвлөжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тэргэнцрийн зам, орц, гарц, ариун цэврийн өрөөг 1 давхарт төлөвлөсөн байна.

Барилга бүтээцийн шийдэл:

Шивээговь сумын төвд баригдах 320 хүүхдийн суудал бүхий барилга нь 2790.6 м² талбай бүхий 3 давхар. Уг барилгын гадна хананд 360 мм блокон өрлөг өрж, 150 мм EPS хөөсөн полистрол хавтангаар дулаалж, 120 мм тоосон өнгөлгөөтэй.

Цонхыг цагаан өнгийн хуванцар рамтай, 2 давхар вакуум шиллэгээтэй. Анги болон өрөөнүүдэд агаар сэлгэх зориулалтаар төгсгөлийн 2 гэгээвчийг хязгаарлагчтай онгойлттой хийнэ.

-Хаалга: анги танхимуудын хаалга 2 онгойлттой металл хавтастай, шилэн гэгээвчтэй байна. Ангийн хаалганд 2-3 төрлийн тод өнгийн хаалга сонгож, өнгийг дараалуулан хийнэ. Техникийн өрөөнүүдийн, агуулахын хаалга агаар өгөх сараалжтай металл хаалга байна. Ариун цэврийн өрөөнүүдийн хаалга агаар өгөх сараалжтай, шилэн гэгээвчтэй, цагаан өнгийн модон хаалга байна. Гадна хаалга цагаан саарал өнгөтэй дулаалгатай 2 хавтастай металл хаалга байна.

-Шал: өрөө тасалгааны онцлогоос хамаар, зүймэл модон, хулдаасан, бетон шал хиймэл чулуу, плита, зориулалтын модон шал байхаар зурагт тусгажээ.

-Өрөөний дотор засал: Дотор заслын ажлыг БА-04 дүгээр хуудсанд тусгасан ч зөвхөн заслын төрлүүд тусгагдсан, харин өрөө тасалгааны өнгө будгууд тодорхой тусгагдаагүй зөрчил байна.

Усан хангамж цэвэр усны эх үүсвэр нь нэгдсэн шугамаас хангагдах ба төвлөрсөн системд холбогдоно, халуун усыг агшин зуурын халаагчаар төлөвлөсөн байна. Ариун

цэврийн байгууламжаас гарах бохир ус өөрийн урсгалаар гаргалгааны худгаар дамжин бохир усны төвлөрсөн шугамд холбогдохоор тусгагдсан байна.

Агааржуулалт: Хоолны газрын халуун боловсруулалт, угаалгын өрөө, урлагийн болон биеийн тамирын танхимуудад агаар сорох, гаднаас агаар оруулах автомат төхөөрөмж төлөвлөсөн, бусад анги танхим, өрөөнүүдэд ердийн агааржуулалттай байхаар төлөвлөгджээ.

Гэрэлтүүлэг: Анги танхимын таазанд люминисценц, цахилгаан болон техникийн, гал тогоо, ариун цэврийн өрөөний таазанд ус чийгний хамгаалалттай гэрэлтүүлэгч, урлаг зааланд лед гэрэлтүүлэгч байхаар эрүүл ахуйн шаардлагад нийцэхүйц тооцоололтой төлөвлөгдсөн байна.

Барилгын бүтээцийн төлөвлөлтийг инженер хайгуулын Ган хошуу ХХК-ний 2013 оны 7-р сард хийсэн геологийн судалгааны дүнд үндэслэсэн хийсэн байна. Уг судалгаагаар төлөвлөж буй барилгын талбай нь инженер геологийн дунд зэргийн нөхцөлтэй, 8 м гүн өрөмдөхөд хөрсний ус илрээгүй, улирлын хөлдөлтийн норматив гүн нь шавар, шавранцар хөрсөнд 2.34м, том хэмжээнд хөрсөнд 3.35м, газар чичирхийллийн 6 баллын бүсэд оршдог гэж тодорхойлогджээ.

Энэхүү барилга баригдах газар олголтод эрүүл ахуйн чиглэлээр дүгнэлт гаргаж байгаагүй байна.

Дээрх байдлаас **ДҮГНЭХ НЬ:**

1. Шивээговь сумын төвд баригдах 320 хүүхдийн сургуулийн барилгын зураг төслийг хянахад инженерийн хангамжийн (ус хангамж, агаар сэлгэлт, дулаан, ариутгах татуурга) ерөнхий шийдэл, нарны тусгал, барилгын давхрын байгуулалт, ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай өрөө тасалгааг бүрэн төлөвлөсөн нь Эрүүл ахуйн тухай хуулийн дугаар зүйлийн 6.2, Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах норм, дүрэм БНБД 66-88, Боловсрол соёл шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2015 оны А|253\251\173 тоот тушаалаар батлагдсан “Цэцэрлэг, ЕБС, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлага”, МХЕГ-ын даргын 2017 оны А|179 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”-ийн шаардлагыг хангаж байна.

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ



Ж.ОЮУНЧИМЭГ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ

Д Ү Г Н Э Л Т

Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум 2 дугаар баг,
E-mail: govisumber.emer@yahoo.mn; <http://www.nema.mn> Утас: 7054101,

2020.04.06

№41/01.

Сүмбэр сум

1. Барилга байгууламжийн байршил нэр. Говьсүмбэр аймаг Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга
2. Газрын захирамж: Говьсүмбэр аймгийн засаг даргын 2010 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн 158 дугаар захирамж
3. Зургийн шифр, зураг төслийн компани: “Эм Эс Эл” ХХК” тусгай зөвшөөрөл ЗТ17-39/16 зургийн шифр MSL-20-09
4. Барилга байгууламжийн зориулалт: Говьсүмбэр аймаг Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга
5. Хүчин чадал: Говьсүмбэр аймаг Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга
6. Газар хөдлөлтийн зэрэг: 6 балл
7. Галд тэсвэршилтын зэрэг: 2

Хоёр. Барилга байгууламжийн зураг төслийн
галын аюулгүй байдлын дүгнэлт

1. Шивээговь сумын төвд баригдах 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын шугам тоноглол, угсралт, галын дохиоллын сиситем, цахилгаан монтажыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх.
2. Барилгын модон хийц бүтээцийг гал тэсвэршилтийн нэвчилгээ хийх, гал шатдаггүй будгаар будах. / Галын аюулгүй дүрэм “БНБД 21-06-10”/
3. Барилгын ханын дулаалга болон дээврийн дүүргэгч материалыг галд тэсвэртэй материалаар төлөвлөх.
4. MNS 6576-2016 дагуу галын усны даралтад цэгийн /кран/ төлөвлөх.
5. Галын дохиоллын хүлээн авагч станцыг хүн 24 цагаар байрлах өрөө тасалгаанд байрлуулах. Галын дохиоллын мэдээлэгчийн байрлалыг технологийн байгуулалт, дам нуруу, хана, хүртэлх зай, мэдээлэгчийн хүчин чадалтай уялдуулж зөв төлөвлөж, түүний дагуу гүйцэтгэх. БНБД 21-04-05
6. Аваарын гэрэлтүүлэг норм стандартын дагуу төлөвлөх
Дээрх шаардлагын дагуу ажлын зургийг засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаардлагатай.

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

ДУГНЭЛТ ГАРГАСАН.
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
АХЛАХ ДЭСЛЭГЧ С.ЭНХ-ЭРДЭНЭ





ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨЛД ХЯНАЛТ ХИЙСЭН ТУХАЙ
Д Ү Г Н Э Л Т

Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум 2 дугаар баг,
E-mail: govisumber.emer@yahoo.mn; <http://www.nema.mn> Утас: 7054101,

2020.04.06

№41/01.

Сүмбэр сум

1. Барилга байгууламжийн байршил нэр. Говьсүмбэр аймаг Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга
2. Газрын захирамж: Говьсүмбэр аймгийн засаг даргын 2010 оны 11 дугаар сарын 08-ны өдрийн 158 дугаар захирамж
3. Зургийн шифр, зураг төслийн компани: “Эм Эс Эл” ХХК тусгай зөвшөөрөл ЗТ17-39/16 зургийн шифр MSL-20-09
4. Барилга байгууламжийн зориулалт: Говьсүмбэр аймаг Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга
5. Хүчин чадал: Говьсүмбэр аймаг Шивээговь сумын Ерөнхий боловсролын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилга
6. Газар хөдлөлтийн зэрэг: 6 балл
7. Галд тэсвэршилтын зэрэг: 2

Хоёр. Барилга байгууламжийн зураг төслийн
галын аюулгүй байдлын дүгнэлт

1. Шивээговь сумын төвд баригдах 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын шугам тоноглол, угсралт, галын дохиоллын сиситем, цахилгаан монтажыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хийлгэх.
2. Барилгын модон хийц бүтээцийг гал тэсвэршилтийн нэвчилгээ хийх, гал шатдаггүй будгаар будах. / Галын аюулгүй дүрэм “БНБД 21-06-10”/
3. Барилгын ханын дулаалга болон дээврийн дүүргэгч материалыг галд тэсвэртэй материалаар төлөвлөх.
4. MNS 6576-2016 дагуу галын усны даралтад цэгийн /кран/ төлөвлөх.
5. Галын дохиоллын хүлээн авагч станцыг хүн 24 цагаар байрлах өрөө тасалгаанд байрлуулах. Галын дохиоллын мэдээлэгчийн байрлалыг технологийн байгуулалт, дам нуруу, хана, хүртэлх зай, мэдээлэгчийн хүчин чадалтай уялдуулж зөв төлөвлөж, түүний дагуу гүйцэтгэх. БНБД 21-04-05
6. Аваарын гэрэлтүүлэг норм стандартын дагуу төлөвлөх
Дээрх шаардлагын дагуу ажлын зургийг засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаардлагатай.

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН.
ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ,
АХЛАХ ДЭСЛЭГЧ С.ЭНХ-ЭРДЭНЭ

